

**2024 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 16-НЫ ӨДРИЙН  
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНД НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН УДИРДАХ  
АЖИЛТНААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

Үүргийн биелэлтийг Arial-12 фонтоор бичиж, **2024 оны 01 дүгээр сарын 24-ний “Лхагва” гарагт** багтаан e-doc системээр албан бичгээр ирүүлж, ТЗУХ (ERP Б.Одбаяр)-т файлаар ирүүлнэ үү. **Хугацаа хэтэрсэн, албан бичгээр ирүүлээгүй тохиолдолд биелэлт ирүүлээгүйд тооцохыг анхаарна уу.**

№	Өгсөн үүрэг даалгавар	Хариуцах эзэн
<b>НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
1	Дүүргийн хэмжээнд байгаа айл, өрхүүдийн янданг тоолох тооллогын ажлыг зохион байгуулах.	ТХҮХ, Хороод
2	Дүүрэгт байгаа авто машины тоон судалгаа гаргах, авто замын хөдөлгөөний эрчим, дундаж хурдны талаарх статистик, тоон мэдээллийг гаргах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн хэсэг, Татварын хэлтэс, Статистикч
3	Халаалтын зуухнуудын агаар цэвэршүүлэгчийн филтер, ул ширмийг шинэчлэх асуудлыг судалж, танилцуулан холбогдох газарт хүргүүлэх.	ТХҮХ, Илч-Орд ОНӨААТҮГ
4	Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 51 дүгээр хуралдааны тэмдэглэлийн дагуу дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд нийтийн болон амины орон сууцны бүсийг тогтоох, шинэчлэн боловсруулах.	ГЗБА
5	Дүүргийн нутаг дэвсгэр дээр байгаа үл хөдлөх эд хөрөнгийн шинэчилсэн бүртгэлийн ажлыг зохион байгуулах.	СТСХ, Татварын хэлтэс, УБХ
6	Дүүргийн иргэдийн эрт илрүүлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах.	НХХ, ЭМТ
7	2024 оны 3 дугаар сард Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч дүүргийн үйл ажиллагаатай танилцах ажлын төлөвлөгөөг боловсруулж танилцуулах.	ЗДТГ
8	Орон нутгаас мах худалдан авах явуулын цэг ажиллуулах боломжийг судалж, холбогдох шийдвэрийг гарган арилжааны банкуудтай хамтран ажиллах асуудлыг судалж танилцуулах.	ТХҮХ
9	Хог хаягдлаас үүсэж буй байгаль орчны бохирдол нь агаар, хөрс, усны бохирдлыг ихээр үүсгэж байгаатай холбогдуулан Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, үйл ажиллагааны төлөвлөлт хийж ажиллах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ (ХААТ), Багахангай тохижилт ОНӨААТҮГ
10	Дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам талбайн цас, мөсийг цэвэрлүүлэх ажлыг газар дээр нь явж танилцах.	ТХҮХ, Хороодын тохижилт, хог хаягдлын олон нийтийн байцаагчид
11	Гэр хорооллын гудамж, зам талбай болон иргэд, айл өрхийн орчны 50м хүртэлх зам талбайн цас, мөсийг цэвэрлүүлж, халтиргаа гулгаа арилгах ажлын газар дээр нь явж танилцах.	ТХҮХ, Хороод

12	Дүүргийн нутаг дэвсгэр дэх гудамж, зам талбайн халтиргаа гулгаа арилгах ажлаа эрчимжүүлж, давс, бодис цацах ажлаа шуурхай зохион байгуулах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ, Багахангай тохижилт ОНӨААТҮГ
13	Дүүргийн хориглосон бүсээс мал гаргах ажлаа эрчимжүүлж, малыг түр хашаалж хадгалах, түүнтэй холбогдон гарсан зардлыг нөхөн төлүүлэх ажлуудыг зохион байгуулах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ (ХААТ), МЭТ
14	Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай дээр байршуулсан авто машинуудыг журамлах ажлыг зохион байгуулах.	Цагдаагийн хэлтэс
<b>ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР</b>		
15	Дүүргийн 1 дүгээр хорооны СӨХ-ны шинэчлэн байгуулагдсан цагаас хойш хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааны талаар танилцуулга мэдээлэл хийх.	ТХҮХ, СӨХ
<b>ЦАГ ҮЕИЙН ХОЛБОГДОЛТОЙ АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭ</b>		
16	2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр дүүргийн Соёлын ордонд зохион байгуулагдах Сар шинийн баярын үзэсгэлэн худалдаа, арга хэмжээний талаарх мэдээллийг иргэд олон нийтэд хүргэн, зохион байгуулалтад анхаарах.	ТХҮХ, Соёлын ордон, ААНБ-ууд
17	Цасны баярын арга хэмжээг зохион байгуулах.	НХХ, БТСХ, Цагдаагийн хэлтэс
18	Сар шинийн баярт зориулсан Үндэсний бөхийн барилдааны зохион байгуулалтад анхаарч, бэлтгэлийг сайтар хангаж ажиллах.	НХХ, БТСХ
19	Дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн шон дээр гэрлэн чимэглэл хийх, 2 дугаар хорооны байрнуудад туузан гэрэл хийх ажлуудаа ирэх долоо хоногт багтаан бүрэн дуусгах..	ТХҮХ, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
20	Аудитын шалгалт эхлэхтэй холбогдуулан өмнөх оны зөвлөмжийн биелэлт болон холбогдох бусад бэлтгэлийг сайтар хангаж зөрчил, дутагдалгүй дүгнэгдэхэд онцгой анхаарч ажиллах.	Нийт байгууллагууд
21	Багахангай дүүрэг үүсэн байгуулагдсаны 35 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Урлагийн үзлэгийг зохион байгуулах бэлтгэлийг ханган, удирдамж боловсруулж танилцуулах.	НХХ, Соёлын ордон
22	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цасыг зөөж тээвэрлэх ажлыг зохион байгуулах.	Багахангай тохижилт ОНӨААТҮГ
23	Сар шинийн баярыг угтсан их цэвэрлэгээ болон цас цэвэрлэгээны ажлыг зохион байгуулах захирамжийн төсөл боловсруулж танилцуулах, хуваарь гаргах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ
24	Он дамжин хэрэгжиж буй томоохон ажлууд болох БТСХ болон Соёлын ордны барилгын зураг төсөвтэй ашиглагч байгууллагууд сайтар танилцах, мэргэжлийн хүмүүстэй хамтран ажиллах.	ЗДО Б.Болормаа, НХХ, БТСХ, Соёлын ордон
25	Дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрт байгуулагдах Service center-ийн ажлын шийдвэрлэгдсэн төсөв (4.305.1 дөрвөн тэрбум гурван зуун таван сая нэг зуун мянга)-ийн ажлын тоо хэмжээг тодорхой болгох.	ТХҮХ
26	Нийслэлийн төвийн дүүргүүдэд газар олголт зогссонтой холбогдуулан тус дүүрэгт газар эзэмших, өмчлөх иргэдийн хүсэлт нэмэгдэх учраас газар олголттой холбоотой менежмент боловсруулж танилцуулах.	ГЗБА

27	Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан малчин болон мал бүхий иргэдэд 50 хувийн хөнгөлөлттэй үнээр өвс тэжээл олгох тухай Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн хүрээнд холбогдох ажлыг зохион байгуулах.	ЗДО Б.Болормаа, ТХҮХ (ХААТ)
28	Дүүргийн хэмжээнд байгаа хувиараа өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийг ажил хөдөлмөрт зуучлах талаар судалж, ажлын байраар хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.	НХХ ХХҮХ, ЖДҮҮДТ, Хороод
29	Улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд дүүрэгт хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлуудад холбогдох байгууллагууд анхаарах, ажлыг удаашруулж байгаа шалтгаан нөхцлийг судалж (2024.01.18-ны өдрийн дотор) танилцуулах.	ЗДТГ-ын дарга Л.Санжийжамц ХААА, Холбогдох ААНБ-ууд

БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР